

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН БИЧИЛ УУРХАЙГААР
АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ТУХАЙ ГЭРЭЭ**

2019 он

№ 2019/09.

Эрдэнэ сум

“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 2.4, 3.1.3, 6.1.3-т заасны дагуу нэг талаас Дорноговь аймаг (хот)-ийн Эрдэнэ сум, (дүүрэг)-ын Засаг дарга Э.Ганбаяр (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас “*Дорноговь*” нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөл (цаашид “Бичил уурхай эрхлэгч этгээд” гэх)-ийг төлөөлж нөхөрлөлийн дарга (албан тушаал)*Э. Замжүрэв* нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2019 оны 03 дугаар сарын . . . -ны өдөр энэхүү гэрээг (цаашид “Гэрээ” гэх) Эрдэнэ сум (дүүрэг)-д байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Бичил уурхай эрхлэгч этгээд нь Эрдэнэ сумын Бүрдэнэ багийн (дүүрэг)-ийн Хунхат нэртэй газарт орших 5 гектар талбайд журмын 6.1.3-т заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл **нэг жилийн** бичил уурхай (жоншины төрөл) олборлохтой холбогдсон үйл ажиллагааг эрхэлнэ.

1.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сум (дүүрэг)-ын Засаг дарга, бичил уурхай эрхлэгч этгээдийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

Хоёр. Сум (дүүрэг)-ын Засаг даргын эрх, үүрэг

2.1. Сум (дүүрэг)-ын Засаг дарга нь “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 6 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд ногдох талбайн хэмжээг тогтоож, байршилын зургийг гэрээнд хавсаргах;

2.1.2. хог хаягдлын цэгийн байршилыг тогтоож, сатандартын дагуу савтай болох.

2.1.3. бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах талбайг тогтоох;

2.1.4. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу нөхөн сэргээлтийн зардлыг тооцож, бичил уурхай эрхлэгч этгээдтэй тохиролцсоны үндсэн дээр зохих хөрөнгийг товлөрүүлэх;

2.1.5. бичил уурхайн ажилтнуудад (цаанид “ажилтан” гэх) зориулсан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг мэргэжлийн байгууллагын тусlamжтайгаар зохион байгуулах;

2.1.6 Журмын 2.2.2-т заасаны дагуу тухайн аймаг, нийслэлд оршин суугчаар бүртгүүлсэн иргэнийг тухайн талбайд ажиллуулахад хяналт тавих.

2.1.7. энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардах;

2.1.8. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих;

2.1.9. хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа үйл ажиллагааг зогсоох.

2.1.10. Бичил уурхай эрхлэгчид Байгаль орчны нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг ажлын 5 хоногт багтаан батлуулж барьцаа хөрөнгийг байгаль хамгаалах санд төвлөрүүлэх.

Гурав. Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг

3.1. Бичил уурхай эрхлэгч этгээд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд олгосон талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаагаа явуулах;

3.1.2. ажилтнуудыг тогтоосон талбайд суурьшуулах;

3.1.3. сууринийн талбайг тохижуулж, ахуйн болон үйлдвэрийн хог, хаягдлын цэгийг байгуулах;

3.1.4. гэрээгээр олгосон талбайд нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлийн гишүүн бус этгээдийг ажиллуулахгүй байх;

3.1.5. байгаль орчныг хамгаалж, гол, горхи, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх;

3.1.6. бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

3.1.7. хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхөн сэргээлтийн чиглэлээр ажилтнуудал сургалт, сурталчилгаанд бичил уурхайчдыг идэвхтэй оролцуулах;

3.1.8. ашигт малтмалыг аингилан ялгах, баяжуулах үйл ажиллагааг тогтоосон талбайд гүйцэтгэх;

3.1.9. үйл ажиллагаандаа химиин хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглахгүй байх;

3.1.10. Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл, мөн хуулийн 36.4-т заасан хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч этгээд нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 3500 см³ хүргэлх баатамжтай дотоод шатаалтат хөдөлгүүр бүхий 2-оос илүүгүй механизмыг ашиглах;

3.1.11 Бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих.

3.1.12. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу эрх бүхий этгээдийн тогтоосон байгаль орчны нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах ~~2000.000 / 2000~~
~~100.06.92.55408~~ / төгрөгийг нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх;

3.1.13. нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэд зарцуулах;

3.1.14. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу олборлолт явуулсан талбайдаа нөхөн сэргээлт хийж сум, дүүргийн Засаг даргын томилсон комисст хүлээлгэж өгөх;

3.1.15. олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан авах эрх бүхий хуулийн этгээдэд худалдах;

3.1.16. ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар толөх;

3.1.17 шаардлагатай хүний нөөц бүрдүүлэхэд оюутны сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх.

3.1.18 Орон нутгийн амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 2 өрхөд дэмжлэг үзүүлэх.

3.1.19 Орон нутгийн ажилгүй иргэдийг ажлын байраар хангах

3.1.20 Орон нутагт нийгмийн хариуцлага хүлээж тодорхой санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

3.1.21 Журмын 2.2.2-т заасаны дагуу тухайн аймаг, нийслэлд оршин суугчаар бүртгүүлсэн иргэнийг тухайн талбайд ажиллуулах.

3.2. Бичил уурхай эрхлэгч этгээд нөхөн сэргээлт хийж, талбайг хүлээлгэн өгсний дараа ашигт малтмал олборлох өргөдөл дахин гаргах.

Дөрөв. Харилцан хүлээх үүрэг

4.1. Гэрээнд талууд харилцан хүндэтгэх зарчим дээр тулгуурлан хамтарч ажиллана.

4.2. Гэрээний дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлох явцад байгаль орчин, бусад этгээдэд хохирол учруулсан тохиолдолд бичил уурхай эрхлэгч этгээд уг хохирлыг барагдуулах үүрэгтэй. Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчинд учруулсан хохирлыг арилгуулахыг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардана.

4.3. Талууд энэхүү гэрээний биелэлтийг жил бүр хамтран дүгнэж, аймаг (нийслэл)-ийн Засаг даргад дараа оны 1 дүгээр сард багтаан тайлагцана.

4.4 Бичил уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа газарт нөхөрлөлийн гишүүд болон гэрээгээр ажиллаж байгаа этгээдүүдээс гэмт хэрэг болон зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг гаргахгүй байх.

Тав. Маргаан шийдвэрлэх

5.1. Талууд гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцо замаар шийдвэрлэнэ.

5.2. Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

5.3 Бичил уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа газарт нөхөрлөлийн гишүүд болон гэрээгээр ажиллаж байгаа этгээдүүдээс гэмт хэрэг болон зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг гаргасан тохиолдолд гэрээг дуусгавар болгоно.

5.4 Ашигласан талбайн нөхөн сэргээлтийг нөхөрлөл жил болгон хийж ЗД-ын томилсон ажлын хэсэгт хүлээлгэн өгөөгүй тохиолдолд Засгийн газрын 151 дүгээр тогтоолын 6.1.5 дахь заалтыг удирдлага болгоно.

Зургаа. Гэрээний хүчин тоголцор болох

6.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж орон шутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.

6.3. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

Долоо. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

7.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

7.2. Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь түүний нэгэн адил хүчинтэй байх болоод гэрээний салшгүй хэсэг болно.

Гэрээ байгуулсан:

| | | | | |
|---|-------------|------------|---------|-------|
| Дорноговь | аймаг | (хот)-ийн. | Эрдэнэ | сум |
| (дүүрэг)-ын Засаг дарга | | | | |
| /...../ | Э.Ганбаяр / | | | |
| /...../ | | | | |
| ИМНО ЭЦЭГ/ЭХ/-ийн | нэр, | нэр, | гарын | ҮСЭГ, |
| тамга, тэмдэг/ “.....” (нөхөрлөл, хоршоо) | | | төлөөлж | |
| /...../ | Ганбаяр / | нэр, | нэр, | гарын |
| /...../ | | | | |
| Сунгалт: | | | | |
| Дорноговь | аймаг | (хот)-ийн. | Эрдэнэ | сум |
| (дүүрэг)-ын Засаг дарга | | | | |
| /...../ | Э.Ганбаяр / | | | |

20... онысарын өдөр

| | | | | |
|---|---------|------|---------|-------|
| /эцэг/эх/-ийн | нэр, | нэр, | гарын | ҮСЭГ, |
| тамга, тэмдэг/ “.....” (нөхөрлөл, хоршоо) | | | төлөөлж | |
| /...../ | /...../ | | | |
| /эцэг/эх/-ийн | нэр, | нэр, | гарын | ҮСЭГ, |
| тамга, тэмдэг/ | | | | |

20.... онысарын өдөр

2019.03.01
№1

Бүрдэнэ багийн хүнхатын
Сүмийн байршилын зураг
Эрдэнэ сумийн газрын олгосон

Дорноговь аймгийн зориулалтгаар олгосон
уулзанд бийчилүүрэйн
уулзанд

№ 7

Плэис

Талбай 5 га

$X=505229.6950 \quad Y=4880512.2750$
 $X=505303.3170 \quad Y=4880611.9450$
 $X=505705.8349 \quad Y=4880493.4997$
 $X=505630.0643 \quad Y=4880389.0343$

№ 8

Джаргалсайхан
Зураг юйлдсэн: Газрын даамал

Чөнбөд
Тэл-

Зураг юйлдсэн:

$X=505106.07$
-